



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2015 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/351

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих” хөтөлбөр батлах тухай 278 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Нийслэлийн “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд хөтөлбөр”-ийг боловсруулах Ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Нийслэлийн “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд хөтөлбөр”-ийн төслийг 2015 оны 2 дугаар улиралд багтаан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар оруулж, батлуулахыг Ажлын хэсэг /Т.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Э.БАТ-ҮҮЛ



Нийслэлийн Засаг даргын 2015 оны
Агустсарын 27-ны өдрийн
А351 дугаар захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН “ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ”
ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Т.Бат-Эрдэнэ	Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүд	С.Баярбаатар	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
	С.Отгонгэрэл	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Г.Пүрэвсүрэн	Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын дарга
	Э.Тэмүүлэн	Нийслэлийн Эдийн засгийн хөгжлийн газрын дарга
	Б.Одгэрэл	Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв НӨҮГ-ын дарга
	А.Гэрэлзаяа	Аж үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	Б.Арвинбаяр	ШУТИС-ийн Хөгжлийн бодлого, мониторингийн газрын дарга /зөвшилцсөнөөр/
	Д.Бямбасайхан	Хоёрдогч түүхий эдээр хөдөлмөр эрхлэгчдийн үндэсний холбооны ерөнхийлөгч /зөвшилцсөнөөр/
Ц.Ням-Осор	Жижиг, дунд бизнесийн хөгжлийн төвийн тэргүүн /зөвшилцсөнөөр/	
Нарийн бичиг	П.Эрдэнэсүрэн	Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн